



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 370

Улаанбаатар хот

“Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчаас зар сурталчилгаа явуулах тухай журам”
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчаас зар сурталчилгаа явуулах тухай журам”-ыг баталсугай.
2. Энэхүү журмыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдүүлж олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.


ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000621

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны
10 дугаар сарын 23-ны өдрийн 370 дугаар
тогтоолын хавсралт



ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭД, ҮНЭТ ЦААС ГАРГАГЧААС ЗАР СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчдаас зар сурталчилгаа явуулахад тавигдах шаардлагыг тодорхойлох, зар сурталчилгааны материалын агуулга, түүнд орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх, зар сурталчилгааг зогсоох, сэргээх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан утгаар ойлгоно.

1.3 Үнэт цаасны зах зээлд зар сурталчилгаа захиалагч гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1-14, 24.1.18-д тус тус заасан үйл ажиллагаа эрхлэгчид, нийтэд санал болгон үнэт цаас гаргасан этгээдийг зөвхөн ойлгоно.

1.4 Үнэт цаасны зах зээлд зар сурталчилгааг Хороонд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрсөн мэдээллийн хэрэгслээр дамжуулан явуулна.

Хоёр. Зар сурталчилгаанд тавигдах шаардлага

2.1 Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчийн зар сурталчилгаа нь Зар сурталчилгааны тухай хуулийн 6.2, 6.3-д заасан шаардлагаас гадна зар сурталчилгаа захиалагчийн нэр, түүнтэй холбоо барих хаяг, утас зэрэг мэдээллийг заавал агуулсан байна.

1.2 Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч нь олон нийтэд хандсан зар сурталчилгаа хүргэхдээ дараах зүйлсийг хориглоно.

1.2.1 Тус зар сурталчилгаа захиалагчийн эрхэлж буй үйл ажиллагааны талаар, нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны бүрдүүлбэр, гаргасан нөхцөл, уг үнэт цаастай холбоотой бусад хэлцлийн талаар худал мэдээлэл тусгах;

1.2.2 Үнэт цаас эзэмшигч болон зах зээлд оролцогч бусад этгээдийг төөрөгдөлд оруулахаар бодитой бус мэдээлэл тусгах;

1.2.3 Үнэт цаасны арилжаа болон үнэт цаасыг нийтэд худалдахаар санал болгох явцад нийтэд болон харилцагчид дутуу, худал мэдээлэл өгөх.

1.3 Зар сурталчилгаанд үнэт цаасны арилжаанаас олсон орлого, үнэт цаасны зах зээлд оролцогчдын өнгөрсөн хугацаанд олсон ашгийн талаарх мэдээллийг ашигласан тохиолдолд өнгөрсөн хугацаанд олсон орлого, ашгийн хэмжээ нь ирээдүйд олох орлогын баталгаа биш болох талаар заавал дурдсан байна.

2.4 Энэ журмын 2.2-д заасан нөхцөл байдалд зохицуулах байгууллагын гишүүнээр элссэн Өөрийгөө зохицуулах байгууллага хяналт тавина.

2.5 Зар сурталчилгаа захиалагчид өөртэй нь ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй эсхүл, ижил төрлийн үнэт цаас гаргасан зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчийн сул талыг зар сурталчилгаандаа дурдахыг хориглоно.

2.6 Хэрэв зар сурталчилгаанд бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцлийн талаар ямар нэгэн мэдээлэл орсон тохиолдолд харилцагч, хөрөнгө оруулагчийн ирээдүйд олж болох орлогод нөлөөлөх нөхцөл байдал, тэдгээрийн төлөх нийт зардлын талаар бүрэн мэдээллийг тусгах үүрэгтэй.

2.7 Холбогдох хууль тогтоомжийн дагуу нийтэд нээлттэй байх бүхий л мэдээлэл, Хороо болон бусад этгээдийн үйл ажиллагааны явцад нийтэд ил болгосон мэдээ мэдээлэл, нийтэд санал болгон үнэт цаас гаргасан талаарх болон уг үнэт цаасанд хувиарлахаар шийдвэрлэсэн болон хувиарласан ногдол ашгийн талаарх мэдээллийг зар сурталчилгаанд тооцохгүй.

2.8 Зар сурталчилгаа захиалагчид зар сурталчилгааг бүтээх, түгээх үйл ажиллагааны үед Зар сурталчилгааны тухай хуулийн 17.2-д заасан зүйлийг хориглоно.

Гурав. Зар сурталчилгааны эх, түүнд орсон өөрчлөлтийн талаар Хороонд мэдээлэх

3.1 Зар сурталчилгаа захиалагч нь уг сурталчилгааг нийтэд мэдээлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө Хороонд дараах баримт материалыг хүргүүлсэн байна.

3.1.1 Үнэт цаасны зах зээлд зар сурталчилгаа явуулахыг хүссэн гүйцэтгэх захирлын өргөдөл (Журмын хавсралт маягтын дагуу);

3.1.2 Зар сурталчилгааны эх материалын загвар, (аудио, видео ролик (шторк), текст, график, хүснэгт, анонс гэх мэт бусад хэлбэрээр).

3.2 Хорооны Ажлын алба зар сурталчилгаа захиалагчаас ирүүлсэн баримт материалыг мэдээллийн санд холбогдох журмын дагуу хадгалж, ирүүлсэн баримт материалыг буцаан олгохгүй.

3.3 Хороо зар сурталчилгаа явуулахыг хүссэн өргөдөл, холбогдох баримт материалыг хүлээн авсанаас хойш хэрвээ уг зар сурталчилгааны материал нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн байна гэж үзвэл уг зар сурталчилгааг нийтэд түгээхийг хориглох тухай шийдвэр гаргаж болно.

3.4 Хороо дараах үндэслэлээр зар сурталчилгааг нийтэд түгээхийг хориглоно:

3.4.1 Хороонд ирүүлэх баримт материалын бүрдэл дутуу;

3.4.2 Баримт материалын агуулга хоорондоо зөрүүтэй, үнэн бодитой бус мэдээлэл агуулсан нь тогтоогдсон;

3.4.3 Холбогдох хууль, энэхүү журамд заасан шаардлагыг зөрчсөн.

3.5 Энэ журмын 2.2-д заасан нөхцөл байдал үүссэн талаар гуравдагч этгээд болон Өөрийгөө зохицуулагч байгууллагын үндэслэл бүхий мэдээлэлд Хорооны Ажлын алба хяналт тавьж, холбогдох шийдвэр гаргана.

Дөрөв. Зар сурталчилгааг зогсоох, дахин сэргээх

4.1. Хорооны Ажлын алба зар сурталчилгааг нийтэд түгээхийг хориглох шийдвэр гаргасан тохиолдолд Улсын байцаагчийн албан шаардлагаар сурталчилгаа захиалагчид ажлын 1 хоногийн дотор зар сурталчилгааг түгээх үйл ажиллагааг зогсоох тухай мэдэгдэл хүргүүлнэ.

4.2. Зар сурталчилгаа захиалагч, түгээгч нь Улсын байцаагчийн албан шаардлагыг хүлээн авсанаас хойш нэн даруй нийтэд хандсан зар сурталчилгааг түгээх үйл ажиллагааг зогсоох үүрэгтэй. /"Нэн даруй" гэдэг нь ажлын 1 өдрөөс наашхи хамгийн боломжит хугацааг хэлнэ./

4.3. Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч нь холбогдох зөрчил дутагдлыг арилгасан гэж Ажлын албанаас үзвэл тухайн зар сурталчилгааг дахин түгээх хүсэлтийг 10 хоногийн дотор зөвшөөрөх эсэх тухай шийдвэр гаргана.

4.4. Зар сурталчилгааг дахин сэргээх тохиолдолд энэхүү журмын 3.1-д заасан журмыг баримтална.

Тав. Хяналт, хариуцлага

5.1 Хороо энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж холбогдох хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчаас
зар сурталчилгаа явуулах журмын хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗАР СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ ӨРГӨДӨЛ

Огноо:
Хаана: Санхүүгийн зохицуулах хороо
Засгийн газрын IV байр
Бага тойруу 6
Улаанбаатар 46
Монгол Улс.

Хэнээс:
.....
.....

(Өргөдөл гаргагчийн овог, нэр, хаяг, утас, факс, шуудангийн болон электрон
шуудангийн хаяг)

.....
(Хуулийн этгээдийн нэр)

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26.2.6 дахь заалт, Санхүүгийн зохицуулах
хорооны 2013 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан
“Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчаас зар сурталчилгаа явуулах журам”-ыг
үндэслэн

.....
.....
(Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчийн нэр)

.....
.....
(Зар сурталчилгааны эх бэлтгэлийн явц, нийтэд мэдээлэх хэрэгслийн талаарх
мэдээлэл)

.....
.....
(Зар сурталчилгаа түгээгч этгээдийн талаарх мэдээлэл)

.....
.....
(Зар сурталчилгааны товч агуулга)

зар сурталчилгааг нийтэд хандах түгээхээр шийдвэрлэсэн тул холбогдох мэдээллийн
санд бүртгэнэ үү.

Мэдээ, мэдээллийн үнэн зөвийг баталсан:

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/тамга тэмдэг/

.....
/Хуулийн этгээдийн нэр/ /Гүйцэтгэх захирал/
/...../ /...../
/гарын үсэг/ /овог, нэр/